ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр Дугаар А/40 Сүмбэр сум

"Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 дугаар зүйлийн 5.6, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ковид 19 цар тахлын үед сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож нийтийг хамарсан хөл хорио тогтоосонтой холбоотойгоор "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн үйл ажиллагааг эрсдэлийн түвшин өндөр бүхий зорилтот өрхийн хүүхдүүд болон аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийн дунд зохион байгуулсугай.

2."Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3."Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг зохион байгуулж үр дүнг тайлагнан ажиллахыг гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Мөнхчимэг), сэтгэл зүйч (У.Хандсүрэн) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Г.Мөнхдэлгэр)-т үүрэг болгосугай.

4.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 1 852 600(нэг сая найман зуун тавин хоёр мянга зургаан зуу) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

9018379
ATA3412 7219110003

D:/Бичиг хэрэг /тушаал

1270073

206

ГБХЗХгазрын даргын 2021 оны
05 сарын 27-ны өдрийн А/140
дугаар тушаалын 1-р хавсралт

9018379

ОЛОН УЛСЫН “ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл: “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг үндэслэн Шинэ төрлийн коронавирус дэлхийн улс орнуудад дэгдсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссоос халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улс даяар бүх шатны сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосон тул энэ хугацаанд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглоод байна. Хорио цээрийн дэглэмтэй байгаа энэ хугацаанд “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлж, цахим хэлбэрээр хүүхэд, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг хангахаар ажиллаж байна.

Хоёр. Зорилго: Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан цахим хэлбэрээр хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт хүүхдийн хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах, урамшуулах

Гурав. Уриа: “ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ ЖАРГАЛТАЙ” уриан дор 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулах

Дөрөв. Хамрах хүрээ: Эрсдэлийн түвшин өндөр бүхий зорилтот өрхийн хүүхдүүд, Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүд, 12 дугаар анги төгсөж буй сурагчид хамрагдана.

Тав. Үйл ажиллагааны чиглэл:

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
1	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагатай холбоотой зүйл, заалтыг сурталчлан таниулах			
1.1	Хүүхдийн дуу хоолойг сонсох өдрийг тохиолдуулан “Эцэг эхчүүдийн төлөөлөл-ийг	2021.05.20	Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан	Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Гэр бүлийн асуудал

D:/Бичиг хэрэг /тушаал

	оролцуулан цахим уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах		мэргэжилтэн, АХНЗ	хариуцсан мэргэжилтэн, АХНЗ
1.2	Хагас, бүтэн өнчин, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд баярын бэлэг олгох	2021.05.25-31	Нийгмийн ажилтан	Мэргэжилтнүүд
1.3	ШШГазар хоригдож байгаа иргэдийн 20 хүүхдэд бэлэг олгох.	2021.05.15-31	Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн	Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
1.4	Ахлах ангийн төгсөж буй оролцооны клубын манлайлагч, сурагчдыг урамшуулах.	2021.05.15-31	Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн	Мэргэжилтнүүд
1.5	АХНЗ-ийн манлайлагч хүүхдүүдийг урамшуулах	2021.05.25	Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн	Мэргэжилтнүүд, АХНЗ

208

ГБХЗХгазрын даргын 2021 оны
05 сарын 27-ны өдрийн А/120
дугаар тушаалын 2-р хавсралт

ОЛОН УЛСЫН "ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР"-ИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1.	Эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн бэлэг	133	6000	798.000
2.	ШШГазар -хоригдож байгаа иргэдийн 20 хүүхдийн бэлэг	20	6000	120.000
3.	АНХЗ манлайлагч хүүхдэд болон ахлах ангийн төгсөж буй оролцооны клубийн манлайлагч, сурагчдыг урамшуулах. /Ном/	21	20.000	420.000
4	Тууз	21	3000	63000
5	Өргөмжлөлийн жааз	21	6000	126.000
6	Уриалга /тараах материал/	100	1500	150000
6	Томилолт	6	12600	75600
7	Шатахууны зардал	3 машин	33000	100.000
Нийт				**1 852 600**

D:/Бичиг хэрэг /тушаал